

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

2019.02.15

Улаанбаатар хот

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл	Үнэлгээ
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1; 4.1.1.1; 4.1.1.2; 4.1.1.6; 			
1	<p>1.1 Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх.</p>	<p>Татварын албаны удирдах албан тушаал, улсын байцаагчийг сэлгэн ажиллуулах, сонгогдохоор нэр дэвшсэн 214 албан хаагчийн “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг хуулийн дагуу хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн 480 албан хаагчдад дүгнэлт гаргуулсан байна.</p> <p>Авлигатай тэмцэх газрын ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн ажил, албан тушаалд шинээр томилох-40, 3 сарын хугацаагаар хураагчаар томилсон-118, гэрээт ажилтнаар-27, ажил, албан тушаалд сэлгэх буюу шилжүүлэн ажиллуулах-182, ажил албан тушаалыг түр орлон гүйцэтгүүлэх /хавсран гүйцэтгэх/-13 томилсон байна.</p> <p>Татварын улсын байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцэж, тухайн албан тушаалыг хашихад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүйг Авлигатай тэмцэх газрын албан бичгээр мэдэгдсэн Татварын ерөнхий газар болон харьяа албадын 111 албан хаагчид Татварын ерөнхий газрын даргын тушаалаар татварын улсын байцаагчийн эрхийг олгох асуудлыг шийдвэрлүүлсэн.</p>	100
	<p>1.2 Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх</p>	<p>Монгол Улсын Татварын албанд ажиллаж буй албан хаагчдын ёс зүй, нэр хүнд, харилцааны соёлыг дээшлүүлэх зорилгоор 2018 оныг “Чадварлаг, хариуцлагатай албан хаагч, чанартай, хүртээмжтэй төрийн үйлчилгээ” гэсэн зорилтыг албаны хэмжээнд дэвшүүлэн ажилласан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол болон 01 дүгээр албан даалгаврыг Татварын албаны хэмжээнд хэрэгжүүлэх ажлын шинэчилсэн төлөвлөгөөг боловсруулж ТЕГ-ын даргын 2018 оны А/151 дүгээр тушаалаар батлуулж, 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр цахимаар татварын нийт албадад хүргүүлж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах зарим асуудлаар 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 03/3089 дүгээр албан бичгээр татварын албадад чиглэл хүргүүлсэн.</p> <p>Удирдах ажилтны сонгон шалгаруулалт: Удирдах ажилтны 6 ажлын байранд санал болгосон 12 хүний материалыг батлагдсан тухайн ажлын байр (албан тушаалын) тодорхойлолтод нийцэж байгаа байдлаар харьцуулан дүгнэж Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасны дагуу сонгон шалгаруулж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн Б/659 дүгээр тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газар, Татварын удирдлага, хамтын ажиллагааны газар, Хуулийн</p>	80.0

		хэрэгжилтийг хангах газар, Эрдэлийн удирдлагын хэлтэс, Мэдээллийн технологи статистикийн төвийн дарга нарыг тус тус томилгов.	
1.3 Нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх		Татварын албан хаагчдын сахилга, хариуцлагын чиглэлээр 2018 оны 03 дугаар сарын 21-23-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан Татварын албаны удирдах ажилтны зөвлөгөөнөөр “Сахилгын шийтгэл ногдуулахад анхаарах зарим асуудал” гэсэн сэдвээр тус албаны удирдах ажилтнуудад сургалт зохион байгуулсан. Мөн 1 дүгээр сард Нийслэлийн Татварын газар, 3 дугаар сард Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн ажилтан албан хаагчдад ёс зүй харилцааны сэдвээр сургалт зохион байгуулж, тус ажлын үр дүнд ёс зүйн асуудлаар утсаар ирж буй гомдол 80 хувиар, бичгээр ирсэн гомдол өнгөрсөн мөн үеийнхээс 50 хувиар буурсан байна.	90.0
1.4 Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх		Татварын алба болон албан хаагчдын ёс зүй, авлига, сахилга хариуцлагатай холбоотой мэдээллийг иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүднээс Татварын ерөнхий газарт 1800-1212 тусгай дугаарын утсыг 2018 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс ажиллуулсан. Татварын албаны албан хаагчдын ёс зүй, авлига, сахилга хариуцлагатай холбоотой мэдээллийг 1800-1212 дугаарын утсаар хүлээн авч байгаа талаар сурталчилгааны ажил зохион байгуулж, А3, А6 хоёр төрлийн сурталчилгааны материалын эх бэлтгэн 3'300 ширхэгийг хэвлүүлэн албадад тараах ажлыг зохион байгууллаа. Тусгай дугаарын утасны талаар Татварын албаны цахим хуудсанд баннер байршуулж, цахим хуудсаар болон сошиал хуудсаар сурталчилгаа хийсэн. Тайлант хугацаанд 1800-1212 дугаарын тусгай утсанд нийт 376 дуудлага ирснээс ажилтан албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай хамааралтай гомдол 15 ирснийг харьяаллын дагуу Татварын албадад хүргүүлж, шийдвэрлүүлсэн. Бусад дуудлага нь Татварын албаны үйл ажиллагаа, албадын хаяг утасны дугаар, АТБӨЯХАТатвар, и-баримтын талаар асууж лавласан дуудлага ирсэн байна. Татварын албадад 2 удаагийн цахим шуудангаар ёс зүй сахилга хариуцлага алдсан зөрчилд нотлох баримт бүрдүүлэх, зөрчлийн хэлбэрийг хууль журмын дагуу зөв тогтоон ёс зүйн хороогоор оруулах, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагааг хуулийн дагуу явуулж, тайлбар гаргуулах зэрэг асуудлаар чиглэл хүргүүлсэн.	90.0
Эрх зүйн үндэслэл:			
<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.10.1; 4.1.1.10; 			
2	2.1.Авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, чиглэлээр албан хаагчдад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг	Татварын ерөнхий газрын Сургалтын төвөөс “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг Чингэлтэй, Хан-Уул, Багахангай, Багануур, Налайх, Баянзүрх дүүргийн Татварын хэлтсүүдэд 2018 оны 10 дугаар сарын 15-аас 11 дүгээр сарын 15-ны хооронд онлайнаар зохион байгуулсан. Сургалтад УТОХГ, нийслэл, дүүргийн Татварын газар, хэлтсийн 223 ТУБ, 21 аймгийн 323 ТУБ, нийт 546 татварын улсын байцаагч хамрагдсан. Татварын албанд хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, тайлагнах ажил хариуцсан 32 эрх бүхий албан тушаалтан ажиллаж байна. ЭБАТ солигдох бүрт АТГ-т мэдэгдэж тус газраас өгсөн зааврын дагуу сургалт явуулж, гарын авлага материалаар ханган ажиллаж байна. Мөн Авлигатай тэмцэх газрын сургалтын төвд зохион байгуулж буй Авлигын эсрэг сургалтад нийтийн албан тушаалтны, бусад нэгжийн албан тушаалтны, нийтийн албанд анх удаа сүүлийн 1 жилийн	90.0

<p>төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах</p>	<p>хугацаанд томилогдсон ажилтны, захиргаа, удирдлагын нэгжийн дарга нарын, хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтны, худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтны, дотоод хяналт, аудитын нэгжийн дарга нарын, санхүү төсөв хариуцсан албан тушаалтны, хуулийн асуудал хариуцсан ажилтнуудыг, төрийн үйлчилгээний албан хаагчдын чиглэлээр ТЕГ, УТОХГ, нийслэл, дүүргийн Татварын албадын нийт 235 албан хаагчдыг хамруулаад байна. Татварын ерөнхий газраас авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, татварын албаны үйл ажиллагаа, албан тушаалтны ёс зүйд хяналт тавих чиглэлээр Авлигатай тэмцэх газартай хамтран олон нийтийн хяналтын дэд зөвлөлийн 3 гишүүнтэй гурвалсан гэрээ байгуулан Татварын ерөнхий газрын дэргэд ажиллуулж байна. Тус хяналтын зөвлөлийн гишүүдийн хамтаар ТЕГ-т 2018 оны 12 дугаар сарын 04-07-ны өдүүдэд авлига авдаггүй, үнэнч шударга сайн төрийн албан хаагчид олон байдаг гэдгийг олон нийтэд мэдрүүлэх зорилгоор “Бичгийн хавчаар аян”-ыг зохион байгуулаа. “Бичгийн хавчаар” зүүсэн төрийн албан хаагч нь авлига авдаггүй, эрхэмлэдэг үнэт зүйлтэй, түүндээ үнэнч гэдгийг илэрхийлж байгаа юм.</p>	
<p>2.2. Төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон Авлигын эсрэг хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх</p>	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Авлигын эсрэг Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг 2018 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр баталж, татварын албадад цахимаар хүргүүлэн, ma.mn цахим сайтад байршуулж, батлагдсан төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр албадаас авч дүгнэн ажиллалаа. Мөн шийтгийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18.5-т “...хуулиар зөвшөөрснөөс өөр ажил албан тушаал давхар эрхлэхийг хориглох ...” гэж заасны дагуу 6 албан тушаалтанд давхар ажил эрхлэж буй асуудлаа шийдвэрлэх талаар мэдэгдэл хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.</p>	<p>90.0</p>
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.1; 4.1.2.2 		
<p>3 3.1.Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг иргэд, олон нийт, сонирхогч бүлэгт мэдэгдэх, санал авах ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх</p>	<p>ААНОАТ-ын тухай хуульд 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар доорхи заалтыг нэмж баталсан бөгөөд энэ заалт нь тодорхой салбарын аж ахуйн нэгжүүдийн татварыг 90 хувь хөнгөлөх буюу 1 хувийн албан татвартай болгосон өөрчлөлт юм. Үүнд: 19.14.Энэ хуулийн 7.3-т зааснаар тодорхойлогдох татварын жилийн албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, доор дурдсан салбарт үйл ажиллагаа явуулдаг энэ хуулийн 5.3-т заасан албан татвар тологчийн зөвхөн тухайн салбарт явуулсан үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох албан татварыг 90 хувиар хөнгөлнө: 19.14.1.газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа; 19.14.2.хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл; 19.14.3.нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэл; 19.14.4.барилгын материалын үйлдвэрлэл. Дээрхи заалтыг 2018 онд хэрэгжүүлж ажилласан ба 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.</p>	<p>90.0</p>

		<p>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтуудыг хэрэгжүүлэх, бизнесийн өрсөлдөхүйц, таатай орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг өөрийн орны нөхцөлд нийлүүлэн нэвтрүүлэх, сүүлийн үед гарч байгаа татвараас зайлсхийх явдлаас дотоодын татварын бааз суурийг хамгаалах, татварын бааз суурийг цаашид өргөжүүлэх зорилгоор Сангийн яамтай хамтран ААНОАТ-ын хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж олон нийтээр хэлэлцүүлсэн. Хуулийн төслийг боловсронгуй болгоход Сангийн яамтай хамтран ажиллаж, Засгийн газар, УИХ-д өргөн барихад холбогдох судалгаа мэдээллээр ханган хамтарч оролцсон.</p>	
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3: • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.1; 4.1.2.4: 			
4	<p>4.1.Татварын үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах</p>	<p>2017 оны “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-ийн хүрээнд албан татварын чөлөөлөлт, хөнгөлөлт, буцаан олголтын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр буюу татварын орлогын чөлөөлөлт, хөнгөлөлтөд хамрагдахад татвар төлөгчийн бүрдүүлэх материалыг төрийн үйлчилгээний нэгдсэн платформ “ХУР” системийг ашиглан цахимаар 2018 оноос эхлэн татварын албанд хүлээн авах шинэ хэрэглээг нэвтрүүлэхээр Үндэсний Дата төвтэй гэрээ байгуулж, хамтарсан төлөвлөгөө гарган ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Орон сууцны орлогын чөлөөлөлт болон сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэхэд бүрдүүлэхтэй холбогдуулан “ХУР” системээс татвар төлөгчийн гарын хурууны хээг ушуулах төхөөрөмжийн тусламжтайгаар иргэний үнэмлэхийн лавлагаа, үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа, нийгмийн даатгалын шимтгэлийн лавлагааг авдаг боллоо. “ХУР” системийг ашиглан үйлчилгээг хөнгөвчилснөөр орон сууцны чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгч 12 ширхэг материал бүрдүүлдэг байсан бол 5 ширхэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах татвар төлөгч 9 ширхэг материал бүрдүүлдэг байсан бол 3 ширхэг материал бүрдүүлдэг болсон. • ХУР системийг ашиглах цахим хичээл бэлтгэж бүх албадад хүргүүлж, заавар зөвлөмжөөр хангах, инженерийг томилон утсаар системийг ашиглахтай холбоотой заавар өгөх, сүлжээ ашиглан алсаас байцаагчийн компьютерт хандаж програмыг суулгах, алдааг засах зэрэг ажиллагааг өдөрт дунджаар 5-10 удаа гүйцэтгэсэн. ХУР системийг ашиглан 18’000 гаруй иргэдээс хөнгөлөлт чөлөөлөлтийн материал хүлээн авсан байна. <p>1800-1288 дугаарын дуудлагын програмыг шинэчлэх, боловсронгуй болгох ажлын хүрээнд 2017 оны Δ/35 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг програмын явц өнөөгийн байдалд дүгнэн шинжилгээ хийж, цаашид програмыг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгааг үндэслэн 2018 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтыг тусгуулан програм шинэчлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>1. ГТСМТТ УУТ-аас 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр ирүүлсэн загварын дагуу дуудлагын програмын шаардлага, баримт бичгийг боловсруулан 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Татварын удирдлагын нэгдсэн систем /ТУНС/-ийн төслийн багт хүргүүлсэн. Энэ нь ТУНС-ийн төслийн багт “Татварын үйлчилгээ” нэртэй програм болгон хүлээн авсан.</p>	80.0

		<p>2. Татварын үйлчилгээний програмын баталгаажуулахыг нягтлан 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр нэмэлт оруулах 6 саналын хамт хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> • ТУНС-ийн төслийн хүрээнд "Татварын албаны үйлчилгээ" програмыг илүү боловсронгуй болгох зорилгоор Дуудлагын төвүүд /УБЦТС, ОСНААГ, Юйител групп/-ийн үйл ажиллагаа, ашиглаж буй програмд харьцуулсан судалгаа хийсэн ба бусад улс орнуудын Татварын байгууллагын Дуудлагын төвийн зохион байгуулалтын мэдээлэлд үндэслэн нэмэлтээр оруулах 7 саналыг боловсруулж хавсралтын хамт албажуулан 2018 оны 05 дугаар сарын 30-нд ГТСМТТ УУГ, ТУНС-ийн төслийн зөвлөх багт хүргүүлсэн. 	
4.2. Татвар төлөгчийг эрсдэлээс урьдчилсан сэргийлэх зорилгоор эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зохион байгуулах, хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах		<p>а/ Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын 2018 оны төлөвлөгөө боловсруулахад дараах саналыг хүргүүлсэн. Үүнд: "Эрсдэлийн удирдлагын журам"-ын 6.2-т заасны дагуу татварын албадын 2018 онд хяналт шалгалтад хамрагдах татвар төлөгчдийн тоог тодорхойлж ЭУХ-т хүргүүлж, эрсдэлийг тодорхойлуулсан. Татварын хяналт шалгалтад хамруулах татвар төлөгчдийн тоог 2018 онд ажиллах байцаагчийн орон тоо, жилд ажиллах хүн өдөртэй уялдуулан гаргасан. Мөн 2017 оны хяналт шалгалтын төлөвлөгөөгөөр батлагдсан боловч тухайн ондоо хяналт шалгалтад хамрагдаагүй /томилголт олгогдоогүй/, хяналт шалгалт хийгдэж байгаа боловч шийдвэр гараагүй, ямар нэгэн шалтгаанаар томилголт цуцалсан татвар төлөгчдийн судалгаа, сонголтыг хэрхэн хийх талаархи санал тус тус гаргасан. Зарим албадаас ирүүлсэн мэдээлэл, хүсэлтийг үндэслэн харилцан хамааралтай зарим аж ахуйн нэгжийг төлөвлөгөөнд оруулах санал хүргүүлсэн.</p> <p>б/ Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын 2018 оны сүүлийн хагас жилийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлуудыг боловсруулсан. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> 1.Татан буугдсан, өмнөх онд хяналт шалгалтад хамрагдсан, эрэн сурвалжлах тогтоол гарсан зэрэг шалтгаантай татвар төлөгчдийг хяналт шалгалтад хамруулахгүй байх, 2.Төлөвлөгөө батлахдаа хяналт шалгалтын нэгжийн орон тоо, тухайн жилд ажиллах сарын тоог харгалзан үзэх 4.Татвар төлөгчдийг сонгох сонголтыг зөв /оновчтой байдлаар/ хийх. 5. Албадаас ирүүлсэн саналыг харгалзан үзэх <p>Мөн 2018 оны төлөвлөгөөнд батлагдсан "Номин холдинг" компанитай харилцан хамаарал бүхий 18, "Пума" компанитай харилцан хамаарал бүхий 6, бусад харилцан хамаарал бүхий 16, нийт 40 компанийг хяналт шалгалтад хамруулах ажлыг татварын албадтай хамтран зохион байгуулсан. Хяналт шалгалтаар:</p> <p>а/ "Номин холдинг" компанитай харилцан хамаарал бүхий 18 компанийг шалгаж Илтгэх хуудас-6, Шийтгэлийн хуудас-12-ыг тус тус үйлдэн 7,517,421.4 мянган төгрөгийн зөрчилд 244,976.7 мянган төгрөгийн төлбөр, б/"Пума" компанитай харилцан хамаарал бүхий 6 компанийг шалгаж Илтгэх хуудас-1, Шийтгэлийн хуудас-5-ыг тус тус үйлдэн 3,915,558.7 мянган төгрөгийн зөрчилд 53,544.4 мянган төгрөгийн төлбөр, в/Бусад харилцан хамаарал бүхий 16 компаниас 10 компанийг хяналт шалгалтад хамруулж Шийтгэлийн хуудас 10-ыг үйлдэн 568,069.6 мянган төгрөгийн зөрчилд 67,840.3 мянган төгрөгийн төлбөр тус тус ногдуулсан.</p>	90.0
Эрх зүйн үндэслэл:			

<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.3.3: 				
5	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	5.1. Байгууллагын санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж тухай бүр нь оруулах 8 маягт, сар бүр оруулах 3 маягтын дагуу шилэн дансны сайтад байршуулсан болно. 32 харьяа нэгжийн шилэн дансыг хэрэглэгчээр нэвтрэн шалгаж дутуу оруулсан мэдээллийг хугацаандаа оруулахыг утсаар мэдэгдэн албадын хэмжээнд ил тод байдлыг хангаж ажилласан.	90.0
		5.2. Байгууллагын тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл	Сангийн сайдаас баталж ирүүлсэн 39,697,122.7 мянган төгрөгт багтаан төсвийн зүйл, 33 татварын албадаар хуваарилан 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ТЕГ-ын төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргахад нийт 32.4 тэрбум төгрөг батлагдсанаас 32.4 тэрбум төгрөг хуваарилж 32.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан. Тус мэдээллүүдийг шилэн дансны /http://shilendans.gov.mn/ сайтад хуульд заасан хугацаанд, байгууллагын цахим хуудсанд /http://mta.mn/ байршуулж байгууллагын ил тодын самбарг байршуулан ажилласан.	100.0
		5.3. Сар улирлын төсвийн гүйцэтгэл	Сар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээллүүдийг шилэн дансны /http://shilendans.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудсанд /http://mta.mn/ хуульд заасан хугацаанд байршуулж байгууллагын ил тодын самбарг байршуулан ажилласан.	100.0
		5.4. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан	ТЕГ-ын Төсвийн шууд захирагчийн болон Татварын албаны дүнгээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд үнэн зөв гарган Үндэсний аудитын газар хүргүүлж Сангийн яаманд нэгтгүүлж, төсвийн ил тод нээлттэй байх зарчмыг албаны хэмжээнд хангуулан шилэн данс болон ТЕГ-ын ил тод цэсэнд байршуулсан.	100.0
		5.5. Жилийн эцсийн санхүүгийн тайлан, Төсвийн хэмжээ, хэргэлт, түүний шалтгааны тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт	ТЕГ-ын жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд үнэн зөв гарган Үндэсний аудитын газар хүргүүлсэн. Үр дүнг тооцох хугацаа болоогүй байна.	100.0

		<p>5.6. Төсвийн татварын орлогын мэдээг нээлттэй болгох</p>	<p>УИХ болон Аймаг, Нийслэлийн Иргэдийн Хурлын тогтоолоор Татварын алба 2018 онд улс, орон нутгийн төсөвт нийт 4,402.7 тэрбум төгрөг, улсын төсөвт 2,375.8 тэрбум, орон нутгийн төсөвт 1,107.8 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээр баталсан. Улсын төсөвт 2018 онд төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөний хуваарийг 2018 оны А/08 дугаар тушаалаар батлан, татварын албадад хүргүүлсэн. Төлөвлөгөө боловсруулахдаа татварын албадын сүүлийн 3 жилийн татварын ногдуулалт, төлөлгийн судалгаа, урьд оны татварын өрийн үлдэгдэл, зарим татварын хуульд орсон хувь хэмжээний өөрчлөлт, дэлхийн эдийн засаг болон хөрш орнуудын эдийн засгийн талаар бусад эх сурвалжаас гаргасан судалгаа, Монгол Улсын Их Хурлаас баталсан төсвийн хүрээний мэдэгдэл, макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй уялдуулсан. Улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөөний 1,743.4 тэрбум төгрөг буюу 73.4 хувийг УТОХГ, 546.9 тэрбум төгрөг буюу 23 хувийг нийслэл, дүүргийн Татварын албад, 85.5 тэрбум төгрөг буюу 3.6 хувийг аймгийн Татварын хэлтсүүд төвлөрүүллээ. Орон нутгийн ИТХ-аас 2018 онд 1,107.8 тэрбум төгрөг Орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөө урд оны гүйцэтгэлээс 71.5 тэрбум төгрөг буюу 6.9 хувиар, төлөвлөгөөнөөс 131.4 тэрбум төгрөг буюу 13.5 хувиар тус тус өссөн байна. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний 32.7 хувь буюу 361.7 тэрбум төгрөгийг аймгийн Татварын албад, 67.3 хувь буюу 746.1 тэрбум төгрөгийг нийслэл, дүүргийн татварын албад төвлөрүүллээ.</p>	100
		<p>5.7. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл</p>	<p>Тайлант хугацаанд Япон улсын Жайка олон улсын байгууллага, Олон Улсын Валютын Сан, Азийн хөгжлийн банкны дараах 3 төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслүүдийн хэрэгжилтийг танилцуулахад дараах байдалтай байна. Үүнд: Нэг. Монгол Улсын Татварын албанд Япон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын Татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төслийн 2 дугаар шатны хэрэгжилт явагдаж байна. Тус төслийн хүрээнд 2018 онд 3 үндсэн зорилтын 31 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгаснаас 11 ажил хийгдэж дууссан, 14 ажил хэрэгжиж байгаа, 5 ажил нь Татварын ерөнхий хууль батлагдсаны дараа, 1 ажил нь холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт орсны дараа хэрэгжихээр төлөвлөгдсөн. Хойшлогдсон ажил байхгүй байна.</p>	80.0

		<p>Хоёр: ОУВС, АНУ-ын төрийн сангийн шугамаар хэрэгжиж буй “Татварын удирдлагын шинэчлэл” төсөл, уг төслийн дэд хэсэг “Татвар төлөгчдийн хууль тогтоомж мөрдөлтийг сайжруулах нь” төсөл үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 4 үндсэн модулын хүрээнд хэрэгжүүлсэн байна.</p> <p>Гурав: Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх нь” төслийн хэрэгжилт. АХБ-ны төслийн цаандын хамтын ажиллагааны хүрээг тогтоож, санамж бичиг байгуулах ажлын бэлтгэл ажлыг хангаж, Сангийн яам, АХБ, ТЕГ-ын удирдлагууд 3 талт хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан байх төлөвлөгөөтэй ажилласан байна.</p>	
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; 6.1.7 			
6	<p>6.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжийг бий болгож олон шийтэд дараах мэдээллийг түгээж ажиллах</p>	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, холбогдох тогтоол, журам, зааварт нийцүүлэн зохион байгуулж ажилласан. 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчаар батлуулан tender.gov.mn, mta.mn сайтуудад байршуулсан.</p>	95.0
	<p>6.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур, тендерийн урилга</p>	<p>2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тендерүүдийн бичиг баримтыг холбогдох үнэлгээний хороод боловсруулан төсвийн шууд захирагчаар батлуулан тендерийн урилга, оролцогчдод тавих нийтлэг шаардлагуудыг худалдан авах ажиллагааны цахим сайтаар болон өдөр тутмын сонингоор нийтэд зарласан.</p>	100.0
	<p>6.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл болон шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг жагсааят</p>	<p>Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдын талаарх мэдээлэл, шалгарсан, шалгараагүй хуулийн үндэслэлүүдийг оролцогч тус бүрт хүргүүлэхээс гадна tender.gov.mn, mta.mn, shilendans.gov.mn сайтуудад тухай бүр мэдээлж ажилласан.</p>	100.0
	<p>6.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг</p>	<p>Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилт, хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягыг байгууллагын цахим хаяг болох mta.gov.mn сайтад байршуулсан.</p>	90.0

	6.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, хяналт шалгалтын дүн	Худалдан авах ажиллагаанд аудит хийгдээгүй байгаа болно.	үнэлээгүй
	6.6. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, ТББ-уудаас оролцсон 2-оос доошгүй төлөөллийг заавал оролцуулж байна.	100.0
Эрх зүйн үндэслэл:			
<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.5; 4.1.2.6; 			
7	7.1. Өргөдөл, гомдол, хүсэлтийг утсаар, цахимаар, бичгээр гэх мэт хэлбэрээр хүлээн авч, бүртгэлийг цахимжуулах, шийдвэрлэсэн талаар цахим сайтаар мэдээлэх	Тайланг хугацаанд нийт 674 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн байна. Үүнээс: төрийн захиргаа, хүний нөөцийн чиглэлээр 146 өргөдөл гомдол ирснээс 134-ыг шийдвэрлэн хариу өгч, шийдвэрлэлтийн хувь 91.8 хувьтай, хугацаа болоогүй 12 өргөдөл байна. Мөн нийт 5 албаны 8 албан хаагчид холбогдол бүхий ёс зүй сахилга хариуцлагатай холбоотой гомдол ирүүлсэн. Үүний 1 гомдолд НТГ дээр ажлын хэсэг байгуулан шалгасан. 1 гомдол нотлох баримтын шаардлага хангаагүй шалтгаанаар ёс зүйн салбар хороонд буцаагдсан. Ёс зүйн хорооны дүгнэлтийг үндэслэн 5 албан хаагчийг хууль журмын дагуу дуудан уулзаж, тайлбар гаргуулан, зөрчлийн шалтгаан нөхцлийг тодруулан, нотлох баримтыг шаардлага, хуулийн дагуу бүрдүүлж сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээ авч тушаалын хэрэгжилтийг хангуулан ажилласан. Ирүүлсэн ёс зүйн зөрчилд догоод хяналтыг хууль журмын дагуу хугацаанд нь хийж шийдвэрлэн иргэнд утсаар болон бичгээр хариу өгсөн. Мөн 2018 оны 04 дүгээр сард утсаар 2 гомдол ирүүлснийг хууль журмын дагуу шийдвэрлэн иргэнд утсаар болон бичгээр хариу өгч ажиллалаа.	80.0
	7.2. Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах	2018 оны жилийн эцсийн байдлаар 34'969 татвар төлөгчийг хамруулан үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг нэгтгэлээ. Татварын нэг цэг, цахим, утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээнүүд түргэн шуурхай үйлчилж буй эсэхийг асуухад судалгаанд оролцогчдын 57 хувь буюу 20'092 татвар төлөгч "хангалттай" гэсэн бол 38 хувь буюу 13'114 нь "дунд", 5 хувь буюу 1'787 татвар төлөгч "хангалтгүй" гэсэн байна. Татварын улсын байцаагчийн мэдлэг ур чадвар, харилцааны соёл хандлагын талаар асуусан асуултад мөн дийлэнх нь хангалттай /44-49%/ гэсэн үнэлгээг өгсөн боловч бүрэн гүйцэд сэтгэл ханамжтай бус байгаа нь харагдаж дунд гэсэн үнэлгээг 44-46% нь өгсөн байна.	90.0

		<p>Татварын хууль тогтоомжийн талаарх мэдээллийг дутмаг авч байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Судалгаанд оролцогчид мэдээллийн хүрэлцээ дунд гэж үнэлж байгаа нь илүү нарийвчилсан мэдээллийг хүсч байгаа нь харагдаж байна. Татвар төлөгчид цаг хугацаа орон зайг хэмнэсэн байдлаар буюу утсаар болон цахим сүлжээгээр дамжуулан татварын мэдээлэл зөвлөгөөг авах нь илүү болсон байна. Харин биечлэн очиж зөвлөгөө авах гэсэн хариултыг судалгаанд оролцогчдын 18 хувь нь бөглөсөн байна. Иймд татварын албанаас нэг цэгийн үйлчилгээнээс илүү цахим болон утсаар үзүүлэх үйлчилгээнд онцгой анхаарал хандуулж байна. www.mta.mn цахим хуудсыг сайжруулах, татвар төлөгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх, тэдэнд түгээх шаардлагатай байгаа нь энэхүү судалгааны үр дүнгээс харагдаж байна. Судалгаанд оролцсон татвар төлөгчдийн 7 хувь нь татварын тайлангаа хугацаа хоцроож илгээдэг гэсэн бөгөөд шалтгаан нь тайлан илгээх мэдлэг дутмаг, нягтлан бодогчгүй /26%/, програмтай холбоотой ямар нэг асуудал үүсдэг /24%/, хугацааг мартдаг /16%/, санхүүгийн тайлангаа гаргаж дуусаагүй байдаг /13%/, бусад /21% / гэж хариулсан байна. Тайлангаа хугацаандаа илгээдэг боловч татвараа хугацаанд нь төлдоггүй /45% / татвар төлөгч олон байна. Гол шалтгаан нь санхүүгийн нөхцөл байдлаас хамаардаг гэсэн байна. Татварыг интернет, мобайл банк ашиглан төлөх нь илүү тохиромжтой байдаг гэж судалгаанд оролцогчдын олонхи хариулсан байна. Иймд цаашид татвар төлөгчийн цаг хугацааг хэмнэсэн, орон зайн хувьд хязгаарлагдмал бус хаанаас ч татварын үйлчилгээг авч болох чиглэлээр хөгжүүлэхэд анхаарч байна.</p>	
	<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль 6 дугаар зүйлийн 6.1.8; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2; 		
8	<p>8.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтанг томилж, ЭБАТ-ны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах</p>	<p>Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталсангай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн дагуу Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний төслийг боловсруулан баталж татварын албадад цахимаар хүргүүлэн, mta.mn цахим сайтад байршуулж, батлагдсан төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газарт хүргүүллээ. Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг татварын албадаас хагас бүтэн жилээр хүлээн авч дүгнэн цаашид анхаарах хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2019 оны төлөвлөгөөний төсөлд тусгаад байна.</p>	90.0

		<p>Харьяа татварын албадын ЭБАТ нарыг Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах чиглэлээр албан бичгээр болон цахим шуудангаар мэдээлэл өгч, и-мэйл болон утсаар холбогдон зөвлөмж арга зүйгээр ханган ажиллалаа.</p> <p>2018 онд Татварын ерөнхий газрын 148 албан хаагчийн ХАСХОМ, Татварын албаны нийт 1372 албан хаагчаас хуулийн хугацаанд ХАСХОМ-ийн баталгааны маягтыг хүлээн авч баталгаажуулав. ХАСХОМ-ийн баталгааны маягтыг хоцорсон, гаргаагүй албан хаагч байхгүй болно. Татварын албаны ХАСХОМ-1, ХАСХОМ-2 тайлангийн нэгтгэлийг хийж 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр албан бичгээр Авлигатай тэмцэх газар хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас шалган зааварчлах ажлын хэсэг 2018 оны 04 сараас 2 сарын хугацаанд Татварын ерөнхий газарт ажиллаж тус ажлын хэсэгт шаардлагатай судалгаа, холбогдох материал болон тайлбарыг гаргаж өгсөн.</p>	
	<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.1.12, 6.8: • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 7.2.6, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл; 		
9	<p>9.1.Татварын ажилтны зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэж, мэдээллийг цахим хуудсанд ил тод байршуулах</p>	<p>Монгол Улсын Татварын албанд ажиллаж буй албан хаагчдын 8с зүй, нэр хүнд, харилцааны соёлыг дээшлүүлэх зорилгоор 2018 оныг “Чадварлаг, хариуцлагатай албан хаагч, чанартай, хүртээмжтэй төрийн үйлчилгээ” гэсэн зорилтыг албаны хэмжээнд дэвшүүлэн ажилласан.</p> <p>Татварын албаны ажилтан, албан хаагчидтай хамааралтай гомдол хүлээж авахаар 1800-1212 дугаарын тусгай дугаарын утас ажиллуулж байна.</p> <p>Шудрага, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврыг эрчимжүүлэх талаар Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэлд дурдсан Сахилга хариуцлага дэг журмыг чангатгах тухай албан даалгаврын хүрээнд 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/32 дугаар тушаалаар МУ-ын Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг батлаж хэрэгжүүлсэн. Татварын 33 албанаас төлөвлөгөөний биелэлтийг 1, 2 дугаар улирлаар цахимаар хүлээн авч, нэгтгэсэн. МУ-ын Ерөнхий сайдын 2017 оны 01 албан даалгавар, ТА-ны 2018 оны зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж байгаа Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн хамт олонд 03/1396 тоот албан бичгээр талархал илэрхийлэв.</p>	90.0

		Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол болон 01 дүгээр албан даалгаврыг Татварын албаны хэмжээнд хэрэгжүүлэх ажлын шинэчилсэн төлөвлөгөөг боловсруулж А/151 дүгээр тушаалаар баталж, нийт татварын албадад хүргүүлж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах зарим асуудлаар 03/3089 дүгээр албан бичгээр татварын албадад чиглэл хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.	
	9.2. Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулан, давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаа хийж, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулан, давхар ажил эрхлэлтийн талаарх татварын албаны нэгдсэн судалгаа хийж нэгтгэл хийв.	100.0
	9.3. Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах	Төрийн захиргаа, хууль эрх зүйн нэгжийн үйл ажиллагааны болон хүний нөөцийн дотоод эрсдэлийн талаар албан хаагчдад ойлголт өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга замаа тодорхойлох, санал авах, хамтран хэлэлцэж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах зорилгоор “Төрийн захиргаа, хууль эрх зүйн нэгжийн дотоод эрсдэлийн хүчин зүйлийг тодорхойлох арга зүй” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж санал асуулга авсан уг сургалтад нийслэл, дүүргийн татварын газар хэлтсийн хуулийн зөвлөх, хүний нөөцийн 25 ажилтан оролцов. Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй хамтран Төрийн захиргаа, хууль эрх зүйн нэгжийн үйл ажиллагааны болон хүний нөөцийн дотоод эрсдэлийг тооцох ажлыг зохион байгуулсан.	80.0
Эрх зүйн үндэслэл:			
<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.7.3; 			
10	10.1. Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах	Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг байгууллагын цахим хуудаст байршуулахаас гадна эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn -нд байршуулсан.	90.0
	10.2. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах	Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, дотогш чиглэсэн дүрэм, журам, зааврыг цахим хуудаст байршуулсан.	100.0
Эрх зүйн үндэслэл:			
<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4; 			

11	11.1.Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан зөвлөмж, шийдвэрийг биелүүлэх	Татварын ерөнхий газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Гэрчилгээний үнэ тогтоох тухай А/18 дугаар тушаалыг хүчингүй болгуулах Авлигатай тэмцэх газрын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/8723 дугаар зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх Сангийн яамны төлөвлөгөөний дагуу Татварын ерөнхий газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 02-ны А/71 дүгээр тушаалаар хүчингүй болгон, Сангийн яам болон Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	100.0
<i>Дундаж үнэлгээ</i>			91.61

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ТАТВАРЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:

ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ТАТВАРЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧ



Л.НЭРГҮЙ

П.УНДАРМАА

Д.САЙХАНЧУЛУУН

Б.БУЯННЭМЭХ

Ө.САРАНТУЯА